



**БУЛГАН АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ**

2023 оны 05 сарын 09 өдөр

Дугаар А/351

Булган сум

Хөрөнгө гаргах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх заалт, аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2023 оны XIV Хуралдааны “Булган аймгийн 2023 оны төсөвт өөрчлөлт оруулах тухай” XIV/01 дүгээр тогтоол, аймгийн Засаг даргын “Шинэ хөгжлийн зам” үйл ажиллагааны хөтөлбөр батлах тухай 2020 оны II/04 дүгээр тогтоол, аймгийн Засаг даргын 2023 оны А/112 дугаар захирамжийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Дэлхийн Алтаргана-2024 наадмын бэлтгэл ажлын хүрээнд үзэгчдийн 400 ширхэг сандлыг Улаанбаатар хотоос Булган аймаг хүртэл тээвэрлэх ажлыг Булган сумын иргэн Бүрэнтөгстэй гэрээ байгуулан хяналт тавьж ажиллахыг Нийгмийн бодлогын хэлтсийн дарга (М.Батчимэг)-т даалгасугай.

2. Шаардагдах зардал 500,000 (таван зуун мянга) төгрөгийг “Алтаргана 2024” наадмыг зохион байгуулах бэлтгэл ажлын төлөвлөгөөг хэрэгжүүлэх хөтөлбөрийн зардлаас санхүүжүүлэхийг Засаг даргын Тамгын газар (Д.Алтаншагай)-т зөвшөөрсүгэй

ЗАСАГ ДАРГА

Б.АРИУН-ЭРДЭНЭ

